



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/84

Бүрэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн “Гэрэлтүүлэг” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Б.Отгонхишигт (Үнэлгээний хорооны дарга, Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Н.Хүрэлбаатар (Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, Иргэдийн төлөөлөл)
Гишүүн:	Б.Азжаргал (Үнэлгээний хорооны гишүүн, Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер) Ж.Пүрэв-Очир (Төхөм (1-р) багийн Засаг дарга) Ц.Даваадорж (“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх станц” ХХК-ний Бүрэн дэх салбарын техникч) Н.Энхжаргал (Нийгмийн бодлогын мэргэжилтэн) Ж.Хандсүрэн (Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч)

2. Гэрэлтүүлгийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Отгонхишигт)-д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Санхүү албаны дарга (Ц.Доржпалам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500213